



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/60

Шивээговь сум

Газар эзэмшүүлэх хугацааг  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Иргэн Боржигин овогт Цэндийн Төмөрийн эзэмшиж буй сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Өвгөн хонхор”-т байршилтай өвөлжөөний зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дуусаж байгаатай холбогдуулан газар эзэмших эрхийг өвөлжөөний зориулалтаар 40 жилээр сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Газрын тухай хуулийг дагаж мөрдөхийг иргэн Цэндийн Төмөрт үүрэг болгосугай.

3. Иргэн Цэндийн Төмөртэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 36 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 161